



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, залуучуудын өнөөгийн нөхцөл байдлын үр дүнд үндэслэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг, залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоо, нийгмийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх зорилго, зорилтыг тусгасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг тус тус боловсруулж, 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдуулэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай.

2.Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд боловсрол, залуу малчид, орон нутгийн залуус, хөдөлмөр эрхлэлт, хүмүүжил, ёс суртахуун гэсэн дараах 5 үйл ажиллагааг шаардлагатай санхүүжилтийн хамт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай:

1/эх орондоо дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмших нөхцөл бололцоог бурдүүлэх хүрээнд дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэлээр тухайн жилд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 50-д багтсан сургуулиас багш, судлаач-багш нарыг урьж ажиллуулах, тус сургуулийн салбарыг Монгол Улсад нээх боломжийг судлах, залуучуудын дижитал үр чадварыг сайжруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй боловсрол олгох;

2/гадаадад сурч, боловсрол эзэмшсэн залуучуудыг эх орондоо ирж ажиллаж, амьдрахад болон залуучууд хөдөө, орон нутагт амьдрахад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг хийх, судалгааны үр дүнд тулгуурлан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3/залуу малчдыг дэмжих хүрээнд уламжлалт нүүдлийн мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, дасан зохицох чиглэлээр тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, залуу малчдын гэр бүл төлөвлөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай бизнес эрхлэхийг дэмжих;

4/орон нутгийн залуучуудыг тухайн аймаг, сумандаа тогтвортсуурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангах хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлд, сум бүрт жилд 10-аас дээш өрхийг түрээсийн болон хувийн орон сууцад хамруулах боломжийг судалж, холбогдох тооцооллыг танилцуулах;

5/зах хязгаар нутагт амьдарч буй залуучуудад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

6/залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмыг шинэчлэх, оюутны цагийн хөдөлмөрийн цалин хөлснөөс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг уян хатан тогтоох;

7/залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зарцуулалтын тодорхой хувийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж буй залуучуудад зарцуулах, Залуучуудын хөгжлийг дэмжих санг байгуулах талаар судалж, танилцуулах;

8/өсвөр үе, залуучуудад хүмүүжил, ёс суртахууныг төлөвшүүлэх хүрээнд тэдний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, бие хүн болж төлөвшихөд чиглэсэн үйл ажиллагааг засаг захиргааны нэгжийн Засаг дарга бүр тэгш хамралтын зарчим дээр үндэслэн хэрэгжүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтийн явцыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо (Л.Энхнасан)-нд үүрэг болгосугай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Л.ЭНХНАСАН

